

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА


Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдаж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-т, 25.1.2-т заасныг үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр бүлэг, зүйл, заалт оруулах зэргээр нэмэлт өөрчлөлт орсон тул Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавар, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог тус тус хийлгэж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусган 8 бүлэг 29 зүйлтэй боловсруулсан.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдсан 1995 оноос 2022 он хүртэл нийт үйлдвэрлэл 6.6 их наяд төгрөгөөс 28.5 их наяд төгрөг болж Монгол Улсын эдийн засаг 4.3 дахин тэлсэн. Мөн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн тоо 1998 онд 7.8 мянга байсан бол 2022 оны байдлаар 79.4 мянга болж 10.2 дахин нэмэгдсэн.¹

Түүнчлэн, эдийн засгийн өсөлтөд хувийн хэвшлийн оролцоо улам бүр нэмэгдэж, хувийн хэвшлийн нэгдэл, зохион байгуулалтыг сайжруулан төрийн бодлого, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргах явцад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 1. ДНБ-д хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл

МҮХАҮТ-аас бизнесийн холбогдолтой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд бизнес эрхлэгчдийн оролцооны түвшин ямар байгаа, бизнесийн эрх ашгийг хамгаалах бизнесийн болон мэргэжлийн холбоодын үйл ажиллагаа нь хүртээмжтэй ажиллаж тухайн салбарын бизнес

¹ Үндэсний статистикийн хорооны тоон мэдээлэл, 2015 оны суурь үнээр


эрхлэгчдийг бүрэн төлөөлж, эрх ашгийг хамгаалж байгаа эсэхийг тодруулах зорилгоор 2022 оны 11 дүгээр сард 1603 аж ахуй нэгжээс судалгаа явуулсан бөгөөд судалгааны үр дүнгээс харвал бизнесийн холбогдолтой бодлого, хууль, дүрэм журам шийдвэр гаргах процесст бизнес эрхлэгчдийн оролцоо ямар түвшинд байна гэж үзэж байгаа тухайд тодруулахад судалгаанд оролцсон аж ахуй эрхлэгчдийн 80 хувь нь дунд болон муу, маш муу байна гэсэн бол 16 хувь нь сайн, маш сайн байна гэжээ.

Зураг 2. Төрийн бодлого, хууль, дүрэм, журам, шийдвэр гаргах процесст аж ахуй эрхлэгчдийн оролцоо ямар түвшинд байна вэ?



Олон улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын хувьд голдуу бүс нутгаар хөгжсөн байдаг ба үүний адилаар 1995 оны хуулиар Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэхийг зорьсон. Гэвч 2023 оны 3-р улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж буй 95,143 хуулийн этгээдээс 82,667 аж ахуйн нэгж байгаа ба үүний 60,523 нь буюу 73.2 хувь нь зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа² ба хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа улам бүр нэмэгдсээр байна. Орон нутагт санхүүжилтээ бие даан шийдэх боломж бага, үүнийг дагаад танхимын хүний нөөц ба чадавх зэрэг шалтгааны улмаас танхимыг бүс нутгийн зарчимд суурилж хөгжүүлэх зорилго биелээгүй учир Монгол Улсын онцлогт тохирсон мэргэжлийн танхимуудыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар бий болгох нь зүйтэй гэж үзсэн.

Зураг 3. МУ-ын зарим тоон үзүүлэлт, нийслэл, орон нутгаар



Эх сурвалж: ҮСХ-ны 2022 оны тоон мэдээлэлд суурилсан болно.

² Үндэсний статистикийн хорооны тоон мэдээлэл

Иймд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Унгар Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийг харьцуулан судалж, олон улсын жишиг зохицуулалтыг харгалзан Монгол Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн бүтэц, зохицуулах асуудлуудын цар хүрээг тодорхойлж, Монгол Улсын эдийн засаг болон гадаад, дотоод худалдаа, хүн ам зүйн тархалт, аж ахуй эрхлэгчдийн төвлөрөлт, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой холбоодын үйл ажиллагааны үр дүнтэй байдал, аж ахуй эрхлэгчдэд дутмаг байгаа санхүүжилтийн төдийгүй техник, боловсон хүчний нөхцөл байдал зэрэгт тулгуурлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн танилцуулгыг бэлтгэлээ.

Хуулийн төслийг дараах байдлаар олон нийтээр хэлэлцүүлж, гарсан саналуудыг тусган бэлтгэсэн.

1. Аймгуудын ХАҮТ-уудтай хийсэн уулзалт хэлэлцүүлэг, 2020.10.22
2. Мэргэжлийн холбоодтой хийсэн уулзалт хэлэлцүүлэг, 2021.11.11
3. Улаанбаатар хотын худалдааны танхимд 2 удаа
 - Ерөнхийлөгч А.Ганхуяг, гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ нарт, 2022.08.10
 - Удирдах зөвлөлийн гишүүд ба удирдлагад, 2022.10.06
4. МҮХАҮТ-ын тэргүүлэгч, УЗ-ын гишүүдэд 2 удаа, 2021.12.12 ба 2022.10.10
5. МҮХАҮТ-ын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөл, МОУА-ын Арбитрчдын зөвлөлд нэгтгэн хийсэн хуулийн төслийн танилцуулга, 2022.09.30

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл болох хуулийн зорилтыг тодорхойлж, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгалаа.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын эрх зүйн байдлыг тодорхойлохдоо Монгол Улсад Үндэсний танхим нь нэг байж, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах зорилгыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улс 2015 оноос эхлэн дэлхийн өрсөлдөх чадварын тайланд орсон ба 2023 оны байдлаар нийт 100 онооноос 35.56 оноогоор тайланд орсон 64 улсаас 62 дугаар байрт эрэмблэгдэж байна. 2016-2018 онуудад өрсөлдөх чадварын оноо өссөн ба 2018 оноос хойш тасралтгүй буурсан.

Иймд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, төр болон улс төрийн нам, эвслээс хараат бус, бие даасан байх зэргээр тодорхойлов.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэх зохицуулалтын дагуу 2015 онд “Улаанбаатар хотын худалдааны танхим” ГҮТББ

байгуулагдан ажиллаж байна. Ийнхүү хууль үйлчлэх 25 жилийн хугацаанд бие даасан танхим ганцхан байгуулагдсан, энэ нь зөвхөн нийслэлд байгаа нь 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 56,8 мянган аж ахуйн нэгжийн 39,3 мянган аж ахуйн нэгж нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Олон улсын жишигт Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь тодорхой зохион байгуулалт, бүтэцтэй байгууллага бөгөөд улс орны эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулдаг байна.

Иймд цаашид бүс нутгийн зарчмаар бус, аж ахуйн нэгжүүдийн явуулж буй үйл ажиллагааны чиглэл, онцлог, салбар зэргийг харгалзан үзэж эдийн засгийн үйл ажиллагааны салбар бүрд нэг салбарын танхим тухайн аймаг, нийслэлд аймаг, нийслэлийн танхим тус тус байгуулан ажиллахаар тусгаж, чиг үүрэг, уялдаа холбоог тодорхойлсон болно.

Хоёрдугаар бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх орчныг сайжруулах, эдийн засаг дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалах үндсэн зорилгын хүрээнд хэрэгжүүлэх бүрэн эрхийг нарийвчлан тусгасан.

Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон эдийн засгийн салбаруудын бодлого боловсруулахад оролцох, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн холбогдох байгууллага, албан тушаалтанд төлөөлөн илэрхийлэх, хамгаалах, тэдгээрийн үйл ажиллагаа, шийдвэрийн үр нөлөөг сайжруулахтай холбоотой санал, зөвлөмж хүргүүлэх болон зөвлөл, хороо, комисс, ажлын хэсэг зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах замаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн илэрхийлэх, хамгаалахаар тусгалаа.

Түүнчлэн хууль, эсхүл Засгийн газрын шийдвэрээр шилжүүлсэн төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж болохоор хуулийн төсөлд тусгаснаар төрийн байгууллагын ачаалал, зардал тодорхой хэмжээнд багасах эерэг үр дагавартай гэж үзэж байна.

Гуравдугаар бүлэгт: Монголын Үндэсний танхимын удирдлага, зохион байгуулалтын харилцааг тусгасан бөгөөд зарим гадаадын орны туршлагаар Үндэсний танхимын Их хурал, Удирдах зөвлөл, Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөл зэрэг удирдлагын бүрэн эрх, чиг үүрэг, хэрхэн сонгогдох, чөлөөлөгдөх зэрэг харилцааг хуульчилснаар бүтэц, зохион байгуулалт тодорхой, тогтвортой байх боломжийг бий болголоо.

Түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалтыг ойлгомжтой, тодорхой болгох зорилгоор олон улсын жишигт нийцүүлэх хүрээнд аймаг, нийслэлийн болон салбарын танхимын дарга нь Монголын Үндэсний танхимын Удирдах зөвлөлийн гишүүн байх зохицуулалтыг тусгалаа.

Дөрөвдүгээр бүлэгт: Аймаг, нийслэлийн болон салбарын танхимыг байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалттай холбогдох харилцааг тусгалаа.

Аймаг, нийслэлийн танхимыг тухайн аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх бөгөөд аймгийн танхим байгуулагдаагүй хоёр болон түүнээс дээш аймгийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд нэгдэж аймаг дундын танхим, эсхүл хэд хэдэн аймгийн танхим хоорондоо нэгдэж аймаг дундын танхим байгуулж болохоор тусгасан.


Харин салбарын танхимыг эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 50-аас доошгүй тооны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж, үйл ажиллагаагаа бие даан хэрэгжүүлэх бөгөөд хэд хэдэн салбарын танхим нэгдэж салбарын дундын танхим байгуулж болохоор тусгалаа.

2021 оны байдлаар Монгол Улсад нийт 3762 бизнес, мэргэжлийн холбоо, эвлэл үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 65 хувь нь 1-2 ажиллагчтай, 86 хувь нь 5 хүртэлх ажиллагчтай байгаа нь эдгээр ТББ, мэргэжлийн холбоодын ихэнх хүний нөөц хангалтгүйг илтгэж байна.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан мэдээллээс үзэхэд зөвхөн барилгын салбарт 24, аялал жуулчлалын салбарт 80, уул уурхайн салбарт 92, хүнсний салбарт 102 ТББ, мэргэжлийн холбоод бүртгэлтэй байгаа ч нийтэд мэдэгдэж үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр салбар тус бүрээр 4-10 орчим байна. Энэ нь салбарын төлөөлөх чадавх сул, зарим салбарын ТББ, мэргэжлийн холбоод нэгдмэл бус байгааг харуулж байна.

МҮХАҮТ-аас явуулсан бизнесийн холбогдолтой бодлого боловсруулахад бизнес эрхлэгчдийн оролцооны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнгээс үзэхэд бизнес эрхлэгчдийн 91% нь Монгол улсад шийдвэр гаргах түвшинд бизнесийн холбогдолтой ТББ-уудын нөлөөлөл дунд ба сул нөлөөтэй гэж хариулжээ.

Зураг 4. Таны бодлоор Монгол улсад шийдвэр гаргах түвшинд бизнесийн холбогдолтой төрийн бус байгууллагуудын нөлөөлөл ямар түвшинд байна гэж үзэж байна вэ?



Иймд салбар бүрийг төлөөлж чадахуйц салбарын танхимын хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн бөгөөд бизнес, эдийн засгийн салбарын аж ахуй эрхлэгчид нь тус бүрийн салбарын асуудлаа салбарын танхим дээрээ хэлэлцэн

ярилцах, орон нутаг, нийслэлийн аж ахуй эрхлэгчид аймаг, нийслэлийн танхим дээрээ хэлэлцэн, ярилцсаны үндсэн дээр нэг шийдэл, шийдвэрт хүрэх боломжтой болох юм.

Мөн Монголын Үндэсний танхим нь шинээр байгуулагдах зарим салбарын танхимын чиг үүргийг тухайн эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн олонхын төлөөллийг нэгтгэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ашгийн төлөө бус хуулийн этгээдэд шууд гэрээний үндсэн дээр шилжүүлж болох зохицуулалтыг тусгаснаар гадна аймаг, нийслэлийн болон салбарын бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, даргын чиг үүрэг, тэдгээрийн зохион байгуулалтын асуудлыг хуульд тодорхой зааж өгсөн болно.

Түүнчлэн гадаадын орны туршлагад үндэслэн аймаг, нийслэлийн болон салбарын танхимын гишүүн болгоны оролцоог хангах, хяналт тавих боломжийг бий болгох, үйл ажиллагаа эмх цэгцтэй, ил тод явуулах боломжийг бүрдүүлэх хүрээнд хяналтын нэгж буюу хяналтын зөвлөлийг бий болгохоор тусгалаа.

Тавдугаарт бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүнчлэл, санхүүжилтийн асуудлыг тусгалаа.

Аймаг, нийслэлийн болон салбарын танхимууд нь Монголын Үндэсний танхимын гишүүн байх бөгөөд харин Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болохоор тусгалаа.

Тодруулбал, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь Монголын Үндэсний танхимд гишүүнээр элсэхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны тодорхой нэг салбарын танхим, эсхүл аймаг, нийслэлийн өөрийн харьяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах аймаг, нийслэлийн танхимд гишүүнээр сайн дурын үндсэн дээр элссэнээр Худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд оролцохоор боловсрууллаа.

Түүнчлэн, Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран хэд хэдэн салбарын танхимд гишүүнээр элсэж болохоос гадна аймаг, нийслэлийн танхимаас гадна салбарын танхимд давхар гишүүнчлэлтэй байж болохоор заасан болно.

Зургаадугаар бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах журмыг тусгасан.

Энэхүү зохицуулалт нь хуулийн төсөлд шинээр тусгасан зохицуулалт бөгөөд Үндэсний танхим нь худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгод хамаарах аливаа асуудлаар бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтантай чөлөөтэй харилцах, мэргэжлийн танхим нь өөрийн хамаарах эдийн засгийн үйл ажиллагааны салбарын асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтантай шууд харилцах, салбар танхим нь өөрийн харьяа засаг захиргаа

нутаг дэвсгэрийн нэгжид хамаарах төрийн байгууллага, албан тушаалтантай шууд харилцах байдлаар зохицуулсан.

Долдугаар бүлэгт: Монголын Үндэсний танхимын үзүүлэх үйлчилгээний талаар тусгасан гарал үүсэл тодорхойлох, гэрчлэх, баталгаажуулах, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлыг гэрчлэх, бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар нэвтрүүлэх баримт бичиг олгох, Хөндлөнгийн магадлал, үнэлгээ, дүгнэлт гаргах, орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал үйлчилгээний тодорхойлолт олгох, арбитрын үйлчилгээ, эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ болон оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тодорхой зааж өгсөн.

Мөн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8.1-д заасны дагуу Үндэсний танхимын дэргэд аж ахуй эрхлэгчийн хооронд үүссэн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлалын төв ажиллах бөгөөд тус төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу баталгаажуулсан захирамж гарч, шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэх хууль зүйн боломжийг бий болгосон.

Наймдугаар бүлэгт: Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хараат бус байдал, үйл ажиллагааны тайлан, тус хуулийг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан болно.

Энэ бүлэгт зааснаар Үндэсний танхим, мэргэжлийн танхим болон салбар танхим нь улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах бөгөөд үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан олон нийтэд нээлттэй ил тод байх талаар зохицууллаа.